



АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ШУУРХАЙ ЗӨВЛӨГӨӨНӨӨС ӨГӨГДСӨН ҮҮРЭГ ДААЛГАВРЫН ХЭРЭГЖИЛТ



2024 оны 05 дугаар сарын 06-ны өдөр

ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР



1. Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй “Шинэ хоршоо” үндэсний хөдөлгөөний хойд бүсийн зөвлөгөөнийг өндөр түвшинд зохион байгуулах.

Хугацаа: Тухай бүрд





Биелэлт: ХХААГ

Бэлчээрийн мал аж ахуйн салбарыг уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөллөөс хамгаалах, малчдад учирсан эрсдэлийг бууруулах харилцааг зохицуулсан “Уламжлалт мал аж ахуйд тулгамдаж байгаа уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах тухай” хууль батлагдсантай холбогдуулан малчдын амьжиргааг дэмжих “Шинэ хоршоо” үндэсний хөдөлгөөний хойд бүсийн зөвлөгөөнийг 2024 оны 05 дугаар сарын 06-ны өдөр зохион байгуулж Орхон, Булган, Хөвсгөл аймгийн 1100 малчин, хоршоодын төлөөлөл оролцож байна.

Хэрэгжилт: Хэрэгжиж байна.



2. Согтууруулах ундаагаар үйлчлэх, худалдан борлуулах тусгай зөвшөөрөл бүхий аж ахуй нэгж, байгууллагуудын ажиллах батлагдсан цагийн хуваарийг 04:00 цаг болгох асуудалд санал танилцуулах.

Хугацаа: Тухай бүрд





Биелэлт: ХЭЗХ

Согтууруулах ундаагаар үйлчлэх, худалдан борлуулах тусгай зөвшөөрөл бүхий аж ахуй нэгж, байгууллагуудын ажиллах цагийн хуваарийг сунгах асуудлаар санал авч, нэгтгэлийг хийж байна. Сунгах асуудлыг ажлын хэсгийн хурлаар хэлэлцэн шийдвэрлэхээр ажиллаж байна.

Хэрэгжилт: Хэрэгжих шатандаа.

МАЙРАМДАА - ДУУЖДА



3. E-mongolia цахим үйлчилгээний нэгдсэн порталд ирсэн өргөдлийн шийдвэрлэлтэд анхаарах.

Хугацаа: Тухай бүрд





Биелэлт: ТЗУХ

E-mongolia цахим үйлчилгээний нэгдсэн порталд ирсэн өргөдлийн шийдвэрлэлтийг хянах нэгдсэн эрх олгох үйл ажиллагаа систем хөгжүүлэлтийн түвшинд хийгдэж байгаа бөгөөд бүрэн дууссаны дараа нэгдсэн байдлаар олгоно гэсэн мэдээллийг E-mongolia систем хөгжүүлэлтийн газраас өгсөн.

Хэрэгжилт: Хэрэгжих шатандаа.

НАЙРАМДАА - ДУУЖДА



4. Хотын хэмжээд түр зогсохыг хориглосон тэмдэглэгээтэй авто зам дагуу болон авто замын 1-р эгнээнд удаан хугацаагаар машин зогсож байгаа асуудалд анхаарч ажиллах.

Хугацаа: Тухай бүрд





Биелэлт: ЦГ

Холбооны уулзвараас Сүмийн уулзвар хүртэл зорчих хэсгийн 1-р эгнээ болон чиглэлийн тээврийн хэрэгслийн зогсоолд автомашинаа байрлуулан орхисон жолооч нарт гудамж замд үүрэг гүйцэтгэж байгаа, Камерын төвд ажиллаж байгаа алба хаагчид Зөрчлийн тухай хуулиар 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс өнөөдрийг хүртэл нийт 976 жолоочид 11520.0 сая төгрөгийн торгуулийн арга хэмжээ авсан ч энэ зөрчил арилахгүй байна.

Иймд цаашид энэ төрлийн зөрчлийг бууруулах үүднээс чиглэлийн тээврийн хэрэгслийн буудал болон зорчих хэсгийн 1-р эгнээнд автомашинаа ихээр тавьж бусдын хөдөлгөөнд саад учруулдаг байршлуудын судалгааг нарийвчлан гаргаж, камержуулан илрүүлсэн зөрчлийг гэрийн хаягаар цахимаар хүргэж, арга хэмжээ тооцдог болох саналтай байна.

Хэрэгжилт: Хэрэгжиж байна.



5. Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй спорт заалыг оройн цагаар иргэдэд үнэ төлбөргүй ашиглуулах чиглэлээр тооцоо судалгаа хийж танилцуулах.

Хугацаа: 05 дугаар сарын 03-ны дотор





Биелэлт: БТСГ

Биеийн тамир, спортын газар нь ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд 7 хоног бүрийн 5 өдөр спортын 8 төрлөөр үнэ төлбөргүйгээр хичээллэх орчин нөхцөлийг бүрдүүлж, спорт заалаар үйлчилж байна.

Иргэдэд үнэ төлбөргүйгээр үйлчлэх спорт заалны өдөр, цагийг дараах хуваарийн дагуу нэмэгдүүллээ. Үүнд:

- А заал 7 хоног бүрийн Лхагва, Баасан гарагт 18.00-20.00 цагуудад
- Б заал 7 хоног бүрийн Мягмар, Лхагва гарагт 18.00-20.00 цагуудад 2024 оны 05 дугаар сарын 07-ны өдрөөс эхлэн хүүхэд, залуучууд, иргэдэд үнэ төлбөргүйгээр үйлчилнэ.

Иргэдэд үнэ төлбөргүйгээр үйлчлэх цагийг нэмэгдүүлснээр 7 хоногт 400-500, сард 1800-2000 иргэн чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх орчин нөхцөлөөр хангагдана. Цаашид иргэдийн спорт заалаар үйлчлүүлэх эрэлт хэрэгцээ нэмэгдвэл 2024 оны 06 дугаар сарын 03-ны өдрөөс өдөр, цагийг нэмэгдүүлж ажиллана.

Хэрэгжилт: Хэрэгжиж байна.



6. Хөх Монгол цогцолборын хашаанд байгаа хөшөө дурсгал, эд хөрөнгийн үлдэгдэл балансыг гаргаж аймгийн ИТХ-д танилцуулах бэлтгэл ажлыг хангах.

Хугацаа: Ойрын хугацаанд





Биелэлт: ОНӨГ

Хөх Монгол цогцолборын хашаанд байгаа 535.9 сая төгрөгийн үлдэгдэл өртөг бүхий хөшөө дурсгал, эд хөрөнгийн жагсаалтыг гарган 2024 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр аймгийн Засаг даргад танилцуулсан. Хөшөө дурсгал, эд хөрөнгийн үлдэгдэл балансын дүнг аймгийн ИТХ-д танилцуулахаар бэлтгэл ажлыг хангаж байна.

Хэрэгжилт: Хэрэгжиж байна.

НАЙРАМДАА - ДУУЖДА



7. Шинээр баригдаж байгаа авто вокзалын үерийн ус зайлуулах сувагчлалын асуудлаар ажлын хэсэг гаргаж газар дээр нь ажиллах, шаардлагатай зураг төсвийг гаргаж танилцуулах.

Хугацаа: 05 дугаар сарын 03-ны дотор





Биелэлт: ХББЗА

2024 оны 05 дугаар сарын 01-ний өдөр ажлын хэсэг (аймгийн ЗДТГ-ын ХБТХОХ, ГХБХБГ, АТТ, ХББЗА) газар дээр нь үзлэг хийж, дараах шийдвэрүүдийг гаргасан. Үүнд:

1. Ажил гүйцэтгэх үе шатны хуваарь гаргах
2. Авто замыг асфальтбетоноор хучих
3. Автобусны сүүдрэвчийн төсвийг гаргах (зохиогчтой зөвшилцөх)
4. Борооны усны сувгийн трассыг ГХБХБГ гаргасны дараа аймгийн ЗДТГ-ын ХБТХОХ зураг захиалах.

Хэрэгжилт: Хэрэгжиж байна.



АНХААРАЛ ХАНДУУЛСАНД БАЯРЛАЛАА

2024 он

НАЙРАМДАА - ДРЧУЖДА

